

# Лук 17 дээрх нарийн ширийн мэдээлэл ба төсөөлөн бодох үйл ажиллагаа

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Лук 17:11–14-ийг анхааралтай уншаад, нарийн ширийн мэдээлэлд анхаарлаа хандуул.

Уншсаныхаа дараа судруудыг харахгүйгээр дараагийн таван асуултад болж өгвөл бүгдэд нь хариулахыг хичээ.

1. Уяман өвчтэй хүмүүс Аврагчид хэр ойрхон байсан бэ?
2. Уяман өвчтэй хүмүүс Аврагчаас юу хүссэн бэ?
3. Аврагч тэдэнд юу гэж хэлсэн бэ?
4. Уяман өвчтэй хүмүүсийн дундаас хэд нь Аврагчийн хүссэн зүйлийг хийх итгэлтэй байсан бэ?
5. Уяман өвчтэй хүмүүс эдгэрээд юу хийсэн бэ?

**Уншсан зүйлээ төсөөлөн бод.**

Өөрийгөө цэвэршсэн уяман өвчтэй хүмүүсийн нэг гэж төсөөл.

- Уяман өвчнөөс эдгэрэх ямар байх бол? Танд ямар мэдрэмж төрөх байсан бэ?
- Яагаад энэ цэдэгт өгүүлснээр тэд “явах зуураа” эдгэсэн гэж та бодож байна вэ? (14-р шүлэг).
- Таны бодлоор Аврагч таныг эдгээсэн гэдгийг мэдээд та юу хийх байсан бэ?